

1. Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний тухайн жилийн санхүүжилтийн гүйцэтгэл 62.7 хувь, тухайн онд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний хэрэгжилт 69 хувьтай буюу хэрэгжилт хангалтгүй байна.
2. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт оновчгүй, 2024 оноос эхлэн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 74.4 хувь нь улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдаагүй, барилга байгууламжийн 52.8 хувь нь төсөвлөлтийн шаардлага хангаагүй ба Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцээгүй ажлуудыг төлөвлөж баталсан байна.
3. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг дунд хугацаагаар төлөвлөхгүй байгаагаас шалтгаалан тухайн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний бэлтгэлийг хангах ажил орхигдсон, бодлогын баримт бичигтэй уялдуулж төлөвлөх тогтолцоо алдагдсан байна.
4. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, урсгал зардал, Засгийн газрын тусгай сан, хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төрөл, төсөвт өртгийн ялгаа зааг, эрэмбэ, ач холбогдол тодорхойгүй байгаа нь хөрөнгө санхүүгийн нөөцийн оновчгүй хуваарилалт, үр дүнгүй зарцуулалтад хүргэж байна.
5. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих барилга байгууламжийг үнэлэх, эрэмбэлэх аргачлал хуульд заасан шаардлагад нийцээгүй, ТЭЗҮ, тоног төхөөрөмж, их засварын ажлыг нэн тэргүүний хэрэгцээ шаардлага ач холбогдлоор үнэлж, эрэмбэлэх зохицуулалтгүй, норм норматив, ашиглалтын хугацааг харгалзан хуваарилах шалгуур үзүүлэлт тодорхойгүй байгаа нь хөрөнгө оруулалтын эрэмбэ алдагдах суурь шалтгаан болж байна.
6. Худалдан авах ажиллагаанд гаргасан гомдлын шийдвэрийн мөрөөр тавих хяналт хангалтгүй, захиалагчийн хуульд нийцээгүй шийдвэрт тооцох хариуцлага сул байна.
7. Төсөл, арга, хэмжээний хэрэгжилтэд тавих захиалагчийн хяналт хангалтгүйгээс барилга байгууламжийн ажилд бодит гүйцэтгэлээс илүү санхүүжилт олгох, зураг төсөв, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгүүлэхгүйгээр хүлээн авах зөрчил давтагдсаар байна.
8. Хэрэгжиж дууссан 2,164.2 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 1148 төсөл, арга хэмжээний 93.8 хувийг ашиглагч байгууллагын өмчид бүртгэсэн, 6.2 хувийг буюу 214.0 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 71 төсөл, арга хэмжээний үр дүнд үүссэн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй байна.



9. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэх тоног төхөөрөмжийн үнэ, өртгийн урьдчилсан судалгаа хийх, судалгаанд үндэслэн төсөвт өртгийг, нэн тэргүүний хэрэгцээ шаардлагыг харгалзан байршил, тоо хэмжээг төлөвлөх эрх зүйн зохицуулалтгүйгээс хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн зарим тоног төхөөрөмжийн ашиглалт хангалтгүй байна.
10. ХХААХҮС, БОУАӨС-ын болон Боловсролын сайдын багцад төсвийн хөрөнгөд бүртгэх боломжгүй, хувийн өмчлөлд шилжих төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төлөвлөж хэрэгжүүлснээс шалтгаалан иргэн, ААНБ-д үнэ төлбөргүй олгох, эзэмшүүлэх ашиглуулах эсвэл түрээсийн гэрээ байгуулах зэргээр Төрийн байгууллага аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд хүрсэн байна.
11. Аймаг, нийслэл, сум, дүүргийг хөгжүүлэх бодлогын баримт бичиг болон хөгжлийн төлөвлөгөөтэй төсөл арга хэмжээний 95.4 хувь нь уялдсан байна.
12. Орон нутгийн хөрөнгө оруулалтын жагсаалтад төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээг тусгасан нь хөрөнгө оруулалтын үр дүнг бууруулж байна.
13. Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа холбогдох хууль, тогтоомжийг бүрэн мөрдөөгүй байна. • Төсөл арга хэмжээний гүйцэтгэлд тавих мэргэжлийн байгууллага, захиалагч, зохиогчийн хяналт хангалтгүйгээс ажлыг чанаргүй, дутуу гүйцэтгэх, чанар байдал нь алдагдах, ашиглалтын шаардлага хангахгүй байх нөхцөлийг үүсгэж байна.